



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 114

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасч,
эргэлтийн хөрөнгөд бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 6 дугаар зүйлийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Хот тохижуулах газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 35,252,549.46 (гучин таван сая хоёр зуун тавин хоёр мянга таван зуун дөчин есөн төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 31,055,817.36 (гучин нэгэн сая тавин таван мянга найман зуун арван долоон төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хуучин стадионы барилгыг нэгдүгээр хавсралтаар акталж, данснаас хасах, акталснаас гарсан материалыг хоёрдугаар хавсралтын дагуу эргэлтийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр.Хот тохижуулах газрын дарга (Д.Очбадрах)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хоёрдугаар хавсралтын дагуу эргэлтийн хөрөнгөд бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

Гурав.Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Дөрөв.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын
20-ны өдрийн 4/4 тогтоолын нэгдүгээр хавсралт

Хот тохижуулах газрын актлах барилга байгууламжийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтад орсон огноо	Ашиглалтыг нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэмжих нэгж	Биет хэмжээ					
1	Стадион	Цэнгэлдэх хүрээлэн			2015	6	35,252,549.46	3,357,385.68	31,055,817.36
<p style="text-align: center;">Дүн</p> <p>31,055,817.36 /гучин нэгэн сая тавин таван мянга найман зуун арван долоон төгрөг гучин зургаан мөнгө/</p>									

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын
20-ны өдрийн ~~///~~ тогтоолын хоёрдугаар хавсралт

Хот тохижуулах газрын актлах барилгын эргэлтийн хөрөнгөд бүртгэх
материалын жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Эргэлтийн хөрөнгөд бүртгэх материал		
			Тоо	үнэ	Нийт
1	Блок	ш	2800	700	1,960,000
2	Тоосго	ш	13000	200	2,600,000
3	Хавтан	ш	92	60000	5,520,000
4	Хаалга төмөр	ш	2	65000	130,000
5	3 см-ын банз	ш	160	3000	480,000
6	Шургааг	ш	13	6000	78,000
7	Палк 0.2*0.2*2.5м	ш	5	15000	75,000
8	Палк 0.2*0.2*4м	ш	8	20000	160,000
9	Нарсан банз 0.3*4м	м	542	3500	1,897,000
10	Рек мод 1.5см/2.3м	ш	751	4000	3,004,000
11	Хучилтын бетон хавтан	ш	12	80000	960,000
	Нийт дүн				16,864,000 (арван зургаан сая найман зуун жаран дөрвөн мянган төгрөг)